Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 1/14149 тоот албан бичгийн хоёрдугаар хавсралт

# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.12.12

| Д/д | Шийдвэрийн нэр, огноо | Зүйл заалтын дугаар | Зүйл, заалтын агуулга | Хэрэгжилтийн тайлан | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжээгүй шалтгаан | Хяналтаас хасах үндэслэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Засгийн газрын тогтоол | | | | | | | |
| 1 | Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогын дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2022-09-05 Дугаар 2022_334 | 5 | 4.Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуульд заасан хуулийн этгээдийг татан буулгах, бүртгэлээс хасах эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгасугай. | Байгууллагын даргын 2025 оны А/19 дугаар тушаалаар Улсын бүртгэлийн багц хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын байгуулан ажиллаж байна. Мөн Монголын хуульчдын холбоо, УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламент судалгаа, хөгжлийн хүрээлэнтэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Хуулийн этгээдийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Монголын хуульчдын холбоо, УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламент судалгаа, хөгжлийн хүрээлэнд Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 5 (тав) жил тутамд хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийх ажилд дэмжлэг хүсч 1/10319 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дугаартай албан бичгийг хүргүүлэн хамтран ажиллаж байна. | | | |
| 2 | 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай<br>2023-02-08<br>Дугаар 2023_49 | 15 | Х-3.3. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 186 захирамжийн дагуу гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг “Invest Mongolia” төвөөс анх үзүүлж эхэлсэн бөгөөд 2025 оноос Хөрөнгө оруулалт, худалдааны газарт хариуцуулан Засгийн газрын 11-р байранд “Нэг цэгийн үйлчилгээний төв” үйл ажиллагаагаа явуулж, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна.<br>Монгол Улсын Засгийн Газраас Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн бариад байна. Уг хуулийн төсөлд манай байгууллагын зүгээс хуулийн нэр томьёог ойлгомжтой болгох, хийдэл давхардлыг арилгах, улсын бүртгэлд бүртгэх хугацааг багасгах, иргэн хуулийн этгээдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх, ялгавартай байдлыг арилгах үүднээс тодорхой саналуудыг хүргүүлсэн болно. Тухайлбал:<br>-Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгө | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оруулалтын босго хэмжээг байхгүй болгох.<br>-Улсын бүртгэлд бүртгэх хугацааг багасгах<br>-Улсын тэмдэгтийн хураамжийн ялгавартай байдлыг арилгах<br>-Ойгомжгүй, тодорхойгүй зүйл заалтуудыг тодорхой болгох гэх мэт<br>E-Mongolia төрийн үйлчилгээний системээр 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн ба 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс E-Business системд шилжүүлсэн бөгөөд лавлагаа, үйлчилгээний тоог нэмэгдүүлж өнөөдрийн байдлаар нийт 12 төрлийн лавлагаа, 43 төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Мөн гадаадын иргэн F-регистрийн дугаараар системд нэвтрэн хуулийн этгээдийн нэр баталгаажуулах хүсэлтийг илгээх болон бусад лавлагаа, үйлчилгээг авах боломжтой болсон.<br>Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл (УБ-12 маягт)-ийг Англи хэлнээ орчуулан гадаадын хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нар авч ашиглах боломжтой байдлаар байгууллагын цахим хуудаст байршуулсан. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2025 оны 12 дугаар сарын байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай 9884 компанийн нээлттэй мэдээллийг www.opendata.burtgel.gov.mn цахим хуудсанд байршуулсан. | | | |
| 3 | Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-05-03 Дугаар 2023_160 | 21 | 2.Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар бүрийн 23-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | 2024 онд эрхийн улсын Ү-2203024452 дугаар бүртгэлд авагдсан 2015.08.21-ний өдрийн Хамтран өмчлөгч хасагдах хэлцлийг хүчингүй болгуулах тухай Хуашенконстракшн Монгол ХХК-ийн 2024.03.07-ны өдрийн 24/09 дугаар албан бичигт 2024.03.14-ны өдрийн 1/3294 дүгээр албан бичгээр, 2024.04.09-ний өдрийн 24/14 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн гомдолд 2024.04.16-ны өдрийн 1/4957 дугаар албан бичгээр, 2024.06.18-ний өдрийн 24/29 дугаар албан бичгээр ирүүлсэн гомдлын хариуг 2024.07.04-ний өдрийн 1/9017 дугаар албан бичгээр, 2024.07.17-ны өдрийн 7/20 дугаар албан бичгээр Хууль зүй, Дотоод хэргийн сайд О.Алтангэрэлд гаргасан гомдлыг 2024.08.14-ны өдрийн 1/10068 дугаар албан бичгээр, 2025.09.19-ны 25/50 дугаар албан бичигт, 2025.12.05-ны өдрийн 1/13739 дугаар албан бичгээр, хариуг тус тус хүргүүлсэн. 2024.09.13-ны өдрийн 24/39 дугаар албан бичгээр ирүүлсэн гомдол ирүүлсэнтэй холбогдуулан Захиргааны ерөнхий хуулинд заасан сонсох ажиллагааны | 100 | Хяналтад байсан асуудлыг Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагаар шалгагдаж, холбогдох үйл ажиллагаа явагдаж байгаа тул хяналтаас хасах саналтай. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дагуу гомдлыг Аюуд ХХК-ийн өмгөөлөгч С.Саруултөгөлдөрт танилцуулахад тэрээр хариу тайлбарыг Аюуд ХХК-ийн 2024.10.31-ний өдрийн 143/С дугаар албан бичгээр ирүүлсэн. | | | |
| 4 | Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215 | 339 | 2.Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдлыг Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан авч, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байхад анхаарч ажиллаж байгаа бөгөөд, үүнтэй холбогдсон гомдол Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс уламжлан ирсэн гомдол тайлант хугацаанд байхгүй байна. | 100 | | |
| 5 | | 340 | 3.Монгол Улсын иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэг болон киоск машинаар | Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар байдлаар Монгол Улсын 16 нас хүрсэн тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт гаргасан 2,008,008 иргэнд | 100 | Монгол Улсын 16 нас хүрсэн 1,774,719 иргэнд тоон гарын үсэг олгогдсон. УБЕГ болон бусад байгууллагын 1,600 гаруй киоск машин ашиглан үнэгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дамжуулан олгох боломжийг судалж, зохих арга хэмжээ авахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (П.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай | тоон гарын үсэг олгосон. Үүнээс гар утсаар 1,108,564 иргэний үнэмлэхэд 899,444 *(Киоск машинаар 166,006)* Монгол улсын иргэдэд үнэ төлбөргүй олгох тоон гарын үсгийг улсын бүртгэлийн 106 киоск машин, бусад байгууллагын 1755 ширхэг цахим /киоск/ машинаар тус тус олгодог болсон. Үүнд:<br>Гэрэгэ системс ХХК-300<br>Голомт банк АТМ-аар -465<br>ХААН банкны АТМ-аар-485<br>Хурдан-505<br>Улсын бүртгэлийн байгууллага, ЦХИХХЯ-тай хамтран төрийн үйлчилгээний Хурдан киоск машинд Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (киоск)-ийг нэгтгэх ажил хийгдэж, систем хөгжүүлэгчээр Гэрэгэ киоск ХХК ажиллаж, туршилтын ажил амжилттай явагдаж, улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин суурилуулахад бэлэн болсон.<br><br>Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (Киоск) 106 ширхэг, Гадаад паспортын захиалгын 10 ширхэг киоск машинаар улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байна. | | үйлчилгээ үзүүлж байна. Үүрэг биелэгдсэн тул хяналтаас хасуулах саналтай. | |
| 6 | Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай | | 4. 4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт | Гадаадын хөрөнгө оруулалттай компани шинээр үүсгэн байгуулах улсын бүртгэлийн үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2025-02-19<br>Дугаар 2025_94 | | татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай. | өдрөөс эхлэн (E-business)-аар үзүүлж эхэлсэн.<br><br>Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулагчдаас Улсын бүртгэлийн ерөнхий газарт болон Засгийн газрын иргэд, олон нийттэй харьцах 11-11 төвд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар өргөдөл, гомдол ирээгүй. | | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | | | |
| Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 7 | 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл<br>2022-10-19<br>Дугаар 2022_50 | | XII.3.2. Хилээр нэвтэрсэн болон улсын бүртгэл, нийгмийн даатгал, татварын байгууллагад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдтэй холбоотой дундын мэдээллийн санг бий болгох талаар зохих арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав. | “Хур” системээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагууд улсын бүртгэлийн мэдээллийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд дундын мэдээллийн сангийн хэвийн ажиллагааг хангах ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 153 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн анхдугаар хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд “Нийгмийн даатгалын ерөнхий газар”, “Татварын ерөнхий газар”-т 2020, 2021 онуудад бүртгэсэн 173 гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн жагаастыг гарган хүргүүлж, нийгмийн даатгал, татвар төлөлтийн талаарх | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээллийг авч холбогдох хяналтыг тавьж, хамтран ажиллаж байна. | | | |
| 8 | 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл 2023-05-03 Дугаар 2023_19 | | XYIII.8.3. Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод төрийн үйлчилгээний цэгийг нээхэд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт. | Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод тухай бүр аюулгүй байдлын хангах талаар дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилладаг болно. Сэлэнгэ аймаг дахь Сүхбаатар төмөр замын боомтын төрийн нэг цэгийн үйлчилгээний цогцолбор ашиглалтад орж, хилийн хяналтын байгууллагууд 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн. | | | |
| 9 | 2024_44. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл / 2025-01-18 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | 44.22.3.6. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагын бүртгэлийн үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, | Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэлээс бусад хуулийн этгээдийн улсын бүртгэлийг Төрийн үйлчилгээний цахим портал /e-business/-аар дамжуулан 12 төрлийн лавлагаа, 43 төрлийн үйлчилгээг тус тус үзүүлж байгаа бөгөөд 2025 онд "Е- | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, "И-Монгол академи" УТҮГ (Б.Мягмарнаран)-т; | Business 2.0" платформоор 417,164 хуулийн этгээдийн лавлагаа, үйлчилгээ | | | |
| 10 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-05 Дугаар 2025_07 | | 7.26.2.2.1. хуулийн этгээд байгуулах шат дамжлагыг цөөлж, цахимжуулах замаар хугацааг багасгаж, ажлын 3 өдөрт багтаан ашгийн төлөө хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэх боломжийг судалж, холбогдох зохицуулалтыг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нарт; (2. Аж ахуйн үйл ажиллагааг эхлүүлэх үе шатанд тулгардаг хүндрэл, шат дамжлага, хугацааг багасгах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгав:) | Хуулийн этгээд байгуулах шат дамжлагыг цөөлж, цахимжуулах замаар хугацааг багасгах зорилгоор И-Бизнес платформоор хуулийн этгээдийн 12 төрлийн лавлагаа 43 төрлийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд байгууллагын даргын 2025 оны А/19 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан.<br>Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг сайжруулах, иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор ЦХИХХЯ-тай хамтран ажиллах төлөвлөгөөг тус яаманд 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хүргүүлж, төлөвлөгөөнд хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг AI ашиглан автоматжуулах программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх, турших, хэрэглээнд нэвтрүүлэх, Хуулийн этгээдийн гэрчилгээг блокчейн технологи ашиглан баталгаажуулах болон | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хуулийн этгээдийн нэрийг хиймэл оюун AI ашиглан баталгаажуулахаар бодлогын даалгавар боловсруулан ЦХИХХЯ-нд хүргүүлсэн. Мөн /ADB/ төслийн хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим системийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлж байгаа Аствишн ХХК-ийн төслийн багийнхантай уулзаж тус системд хуулийн этгээдийн нэрийг AI ашиглан баталгаажуулах ажлыг тусгаж, ажлын даалгавар боловсруулсан. | | | |
| 11 | Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-02 Дугаар 2025_4 | | 1.1. Эрхэлсэн чиг үүрэг, харьяа салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын агентлаг, төв, нэгж, улсын үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн чиг үүрэг, үйл ажиллагааны үр ашиг, үндэслэл, хэрэгцээ, шаардлагад дүн шинжилгээ хийж, нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах замаар өөрчлөн зохион байгуулах, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтэц, орон тоог оновчтой тогтоох, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод | Засгийн газрын 2025 оны 196 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаң Нийслэлийн улсын бүртгэлийн газрын чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж албан хаагчдыг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст 14 албан тушаалыг шилжүүлэн, 6 албан хаагчид 3 сарын тэтгэмж олгон чөлөөлсөн. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шилжүүлэн гүйцэтгүүлэх саналыг холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулж, 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах; | | | | |
| 12 | | | 1.2.. Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулахад зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтны чиг үүрэг, хариуцах ажил нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан хаагчийн болон тухайн агентлагийн харьяа төв, орон нутгийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, компани, гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын хариуцсан чиг үүрэг, ажилтай давхардахгүй байх чиглэл баримтлах; | Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолыг баримтлан Улсын бүртгэлийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар 146 орон тоонд багтаан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/45 дугаар "Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" тушаалаар батлагдсан. | | | |
| 13 | | | 1.3.. Засгийн газрын агентлагийн бүтцийн | Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолыг баримтлан | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэгжийн оноосон нэр нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэртэй давхардахгүй байх, хуульд өөрөөр заагаагүй бол дэд, орлогч даргагүй байх, үндсэн чиг үүрэгт хамааралгүй хэлтэс газар дотор байгуулахгүй байх, хэлтэс нь дотроо тасаг, албагүй байхаар тогтоох чиглэл баримтлах; | Улсын бүртгэлийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар 146 орон тоонд багтаан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/45 дугаар "Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" тушаалаар батлагдсан. Байгууллагын бүтцийн нэгжийн оноосон нэр нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэртэй давхардаагүй. | | | |
| 14 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-07-23 Дугаар 2025_09 | | 5.1.5. Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, цахимжуулж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, хяналт тавьж, салбар дундын уялдаа зохицуулалтыг хангаж ажиллахыг | Иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн 151 үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэн, мэдээллийн чанарыг сайжруулж, цахим системийн чанарыг дээшлүүлэн Төрийн үйлчилгээний нэгдсэн портал (E-Mongolia), (E-business)-аар үзүүлж байгаа нь төрөөс иргэд, байгууллагад үзүүлэх үйлчилгээг шинэ шатанд хүргэх мөн нийгмийн тулгамдсан асуудал авлигал, хүнд суртлыг багасгахад үнэтэй хувь нэмэр оруулж байна. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод. | | | | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | |
| 15 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01 | | 1.3.. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх; | Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ажлын байранд орон нутгийн Цагдаагийн байгууллага, эсхүл гэрээт харуул хамгаалалтын аж ахуйн нэгжтэй хамтран шаардлага хангахуйц дохиолол хамгаалалтын системийг суурилуулах, суурилуулсан өдрөөс гэрээгээр ажиллаж байгаа харуул, манаачтай байгуулсан гэрээг цуцлах арга хэмжээг зохион байгуулан өөрийн барилгатай 12 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2025 оны 3 дугаар улирлын байдлаар дохиолол хамгаалалтын системийг суурилуулан, 40 гэрээгээр ажиллаж байгаа харуул, манаачтай байгуулсан гэрээг цуцалсан. | | | |
| 16 | | | 1.4.. Салбарын хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган, цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг их өгөгдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, ашиглах; | Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, ЦХИХХЯамны Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын дарга нар хамтран 2025 онд “Монгол Улсын суурь мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-г 4 зорилт, 14 арга хэмжээг гүйцэтгэхээр батлан, хэрэгжилт 2025 оны 12 дугаар | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сарын байдлаар 72 хувьтай байна. | | | |
| 17 | | | 1.5.. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах; | Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, шат дамжлагыг бууруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/, /E-business/-аар нийт 151 лавлагаа, үйлчилгээг үзүүлэх арга хэмжээний хүрээнд иргэн, хуулийн этгээдийн цаг хугацаа, эдийн засгийг хэмнэн 2025 оны 11 дүгээр сарын 11 өдрийн байдлаар E-Mongolia системээр иргэний бүртгэлийн чиглэлээр 210,162 үйлчилгээ, 17,008,884 лавлагаа, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 126 үйлчилгээ, 4,363,082 лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 215,714 лавлагаа, E-Business системээр 162,087 үйлчилгээ, 39,363 лавлагаа, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 11 үйлчилгээ тус тус үзүүлсэн байна. | | | |
| 18 | | | 1.6.. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор үндэсний энгийн гадаад паспортын бэлдэц үйлдвэрлэх, бичилт хийх "Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компани гадаад паспортын бичилт | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хийлгэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 234 дүгээр тогтоолоор хөрөнгийг "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨДХХК-ийн төрийн мэдлийн 51 хувьд тооцон хувь нийлүүлсэн хөрөнгө /дүрмийн сан/-д шилжүүлэн, 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр үйлдвэрийг тоног төхөөрөмж, программ хангамж, улсын бүртгэлийн сүлжээг тусгай зориулалтын байранд нүүлгэн шилжүүлсэн. | | | |
| 19 | | | 1.7.. Салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгуулан, шуурхай шийдвэрлэх; | Шинээр байгуулагдсан Засгийн газрын 100 хоногт хэрэгжүүлэх 6 арга хэмжээний саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр 1/8217 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | | |
| 20 | | | 2.2.. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 3.5-д заасны дагуу нууцлах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн болон лавлагааны ач холбогдолгүй 9966 хуудас баримтыг ил болгон байгууллагын архивт шилжүүлж, баримтыг байгууллагын Баримт нягтлан шалгах комисст хүргүүлж, Тагнуулын ерөнхий газарт мэдэгдсэн. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | | | 2.3.. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох; | Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас /www.gov.mn/-д үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг нийтлэх болон "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хуулийн дагуу 5 ангиллын 68 төрлийн нээлттэй мэдээллийг байршуулахаас манай байгууллагад хамааралтай, мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад 59 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй улирал тутам тогтмол байршуулж байна. Shilen.gov.mn-д байршуулсан Улсын бүртгэлийн байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод үнэлгээгээр 3 дугаар улирал 98 хувиар үнэлэгдсэн байна. | | | |
| 22 | | | 2.4.. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/"-тэй уялдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх; | Ёс зүйн дэд хороо нь 2025 онд нийт 14 удаа хуралдаж, ёс зүйн зөрчилтэй гэх 21 гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэж Ёс зүйн зөрчилд тооцох тухай 10, тооцохгүй тухай 10 дүгнэлтийг гаргаж, албажуулан томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. 1 гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн дагуу иргэн нь буцаан авсан. | | | |
| 23 | | | 2.5.. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх; | Засгийн газрын 2025 оны 196 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган Нийслэлийн улсын бүртгэлийн газрын чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж албан хаагчдыг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст 14 албан тушаалыг шилжүүлэн, 6 албан хаагчид 3 сарын тэтгэмж олгон чөлөөлсөн.<br><br>Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1297 дугаартай тушаал "Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг, маргааны явцад хяналт тавих журам"-д заасны дагуу Төрийн албаны хэрэг, маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж, томилсон 10, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа болон бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хохирол нэхэмжилсэн хэрэг, маргаанд томилогдсон 4 нийт 14 хэрэг маргаанд тус хэлтсээс байгууллага төлөөлөн томилогдон ажиллаж байна. | | | |
| 24 | | | 2.6.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах. | 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Хууль зүй дотоод хэргийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах Унгар улсын "Унгарын мөнгөн тэмдэгт хэвлэл компани"-ий удирдлагатай хамтарсан гэрээ, хэлэлцээрийн талаар уулзалт хийх зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 04 дүгээр сарын 21-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Унгар Улсад Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү, Тамгын газрын ахлах мэргэжилтэн Ц.Жавхлант нар албан томилолтоор ажилсан.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан ХАА-ны төлөвлөгөөний хүрээнд урсгал зардлаас шууд гэрээ 2, нээлттэй тендер шалгаруулалт 7, харьцуулалтын худалдан авалт 1, шууд худалдан | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | авалтыг 8 удаа тус тус Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нийт 17 худалдан авах ажиллагааг үнэлгээний ажлын хэсэг зохион байгуулан тайланг хугацаанд нь тайлагнан ажилласан. | | | |
| 25 | | | 3.2.. Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох; | Ерөнхий сайдын 01,02,03,04 дүгээр албан даалгаврын холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | | |
| 26 | ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04 | | 1.2.. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, | Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолыг баримтлан Улсын бүртгэлийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар 146 орон тоонд багтаан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/45 дугаар "Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" тушаалаар батлагдсан. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад; | | | | |
| 27 | | | 1.3.. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад; | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/"-ийг баталсантай уялдуулан тус хорооноос "Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны төлөвлөгөө"-г нийт 13 арга хэмжээний хүрээнд боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | | |
| 28 | | | 1.4.. төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад; | Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/118 дугаартай тушаалаар байгуулагдсан 7 гишүүний бүрэлдэхүүнтэй Ёс зүйн дэд хороо ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.4.1 дэх заалт, "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3.8 дахь хэсэгт заасны гишүүдэд урамшуулал олгож байна. | | | |
| 29 | | | 1.7. Төрийн албаны тухай хуульд | Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт; | төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөөгүй. | | | |
| 30 | | | 1.8.. ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин | Байгууллагын хэмжээнд 2024 онд 29, 2025 онд 36 албан хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт | | | | |
| 31 | | | 2.5.. хуулийн этгээдийн улсын бүртгэлийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор цахимжуулж, хялбаршуулах; | Азийн хөгжлийн банкны Техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “ТА10201-МОН: Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах” төслийн хүрээнд Аствишн ХХК-тай гэрээ байгуулсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн системийг шинэчлэн хөгжүүлэх, цахим гэрчилгээ нэвтрүүлэх үйл ажиллагааг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд төслийн нэгж нь нийт 35–40 удаагийн уулзалт зохион байгуулж, модуль | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүртгэснийг нотолсон улсын бүртгэлийн цахим гэрчилгээг өргөдөл гаргагч хэвлэн авах боломжтойгоор цахим мэдээллийн санд байршуулж болно.” гэж заасны дагуу 2025 онд “E-Business 2.0” платформоор 417,164 хуулийн этгээдийн лавлагаа, үйлчилгээ авсан бөгөөд үүнээс 1,918 хуулийн этгээдэд цахим гэрчилгээ олгогдсон байна. | | | |
| Хэсгийн дундаж: 98.4 | | | | | | | |
| **Нийт дундаж:98.3** | | | | | | | |

Хэрэгжилтийг хянасан:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ДАВААНЯМ ............................ /2025.12.15/
(албан тушаал) (гарын үсэг) (огноо)
тамга, тэмдэг

Хэрэгжилт тайлагнасан:
ХУУЛЬ ЗҮЙ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б. ЛХАГВАСҮРЭН ............................ /2025.12.15/
(албан тушаал) (гарын үсэг) (огноо)